

БУЛГАН АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хутаг-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: БУА-2026/123/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2026 он	Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Батцогт Утас 70342580 Цахим хаяг: Battsogtd@audit.gov.mn Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn “Бэйкер Тилли Далайван Аудит” ХХК-ийн Орхон аймаг дахь салбарын захирал:Д.Мягмарсүрэн Утас: 99030170 Цахим хаяг: dalaivan.et@gmail.com “Бэйкер Тилли Далайван Аудит” ХХК-ийн Орхон аймаг дахь салбарын Аудитор: Б.Пүрэвсүрэн Утас: 99921600 Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.com
---	--

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЭМЯ	Эрүүл мэндийн яам

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс:7034-2580
Цахим шуудан:bulgan@audit.gov.mn

2026.02.24 № 267

танай _____ ны № _____ т

ХУТАГ-ӨНДӨР СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
Б.ТУЯАЦЭЦЭГ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хутаг-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Хутаг-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 118,984.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс давж, дангаараа буюу эсвэл нийтээрээ материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Амбулаторийн барилгын ажилд хийгдсэн 94,116.4 мянган төгрөгийн, төрөхийн өмнөх барилгын 2,500.0 мянган төгрөгийн засварын ажлыг уг барилгад капиталжуулаагүй, үндсэн хөрөнгийн дансанд нийт 96,616.4 мянган төгрөгийг засварын ажил гэж бүртгэсэн. Амбулаторийн барилгад хийгдсэн засварын ажлын зураг, төсөв, ажлын даалгавар, ажил гүйцэтгэх гэрээгүй 2025 онд бүртгэлд тусгасан.
- Уньт багийн эмнэлгийн барилга, Хонгор багийн эмнэлгийн барилга санхүүгийн тайланд тусгагдаагүй. Эдгээр бүртгэлд байхгүй барилгуудад нийт 15,679.6 мянган төгрөгийн засварын ажил үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй байна.
- Тус эмнэлгийн хашаанд орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2020 онд Моргийн байшин баригдсан ч бүртгэлд тусгагдаагүй, харин акталсан

6326050362

Сүрлэн барилгыг бүртгэлээс хасаагүй тэг үлдэгдэлтэй, эмийн санд түрээслүүлэн ашиглаж байна.

- Тээврийн хэрэгслийн дансанд бүртгэлтэй 6 688.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй элэгдлээрээ өртгөө нөхсөн 4 ширхэг мотоциклийг актлуулах шийдвэр гаргуулаагүй, данснаас хасаагүй боловч биетээр байхгүй, хөрөнгийг ашиглагдахгүй болоход заавар журмын дагуу актлуулж данснаас хасахгүй устгадаг зэрэг зөрчил илэрсэн нь

Төсвийн тухай хуулийн 5 дүгээр зүйлийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" УСНББОУС 17-н 24.25 параграф "Барилгын дотор ханыг солих гэх мэт цөөн давтагдах эсвэл дахин үл давтагдах орлуулалт хийх тийм үндсэн хөрөнгийн зүйлсийг мөн олж бэлтгэж болох юм". 14-р параграфт заасан хүлээн зөвшөөрөлтийн зарчмын дагуу," байгууллага нь ийм зүйлсийн орлуулан нэмэгдэж буй хэсгийг хэрэв хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангаж байвал тухайн өртөг зардал гарсан үед үндсэн хөрөнгийн дансны үнэд оруулан хүлээн зөвшөөрнө" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх"; Төрийн болон орон нутгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2-т "Төрийн байгууллага, албан газар төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг нь өөрт олгогдсон эд хөрөнгийн талаар дараах эрх, үүрэгтэй 1/ "өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах" 2/ "улсын төсвөөс олгосон хөрөнгийг Төсвийн тухай хуульд заасны дагуу зарцуулж, тайлагнах" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хэмжигдэхүйц байх", 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" зэрэг заалтуудтай нийцэхгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Хутаг-Өндөр сумын эрүүл мэндийн төв нь 2025 онд эмнэлгийн барилгад 94,116,4 мянган төгрөгийн урсгал засвар хийгдсэн байна. Тайлант онд Эрүүл мэндийн газраас 382,9 мянган төгрөгийн тусгай зориулалттай бараа материал, 23,670,1 мянган төгрөгийн эм боох материал, 3,499 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, Булган аймгаас 94,116,4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй авч санхүүгийн тайланд тусгасан.

Аудитын гол асуудал

Аудитаар үндсэн хөрөнгө, бараа материалын бүртгэл тайлан, цалингийн тооцоолол зэрэгтэй холбоотой хуулийн заалтуудыг зөрчсөнтэй холбоотой 350,243.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, холбогдох шийдвэрийг гаргасан.

Бусад асуудлын хэсэг

Эрүүл мэндийн төв нь 2025 оны зорилго, зорилтоо тодорхойлон гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж 6 зорилтын хүрээнд 49 арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж төлөвлөгөөний биелэлт 90 хувьтай дүгнүүлсэн байна.

Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор "Цалин хөлс шинэчлэн батлах тухай" төрийн албан хаагчдын цалин хөлсийг шинэчлэн тогтоосон байна.

2025 онд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 03 "Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай", 04 "Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" тогтоолуудад өөрчлөлт

орсон байна. Тус Эрүүл мэндийн төв нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд үйлчлүүлэгчийн биеийн байдалд үнэлгээ өгөх, хянах, эрүүл мэндийг дэмжих, аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэхэд орчин үеийн болон уламжлалт анагаах ухаанд тулгуурлан эмнэлгийн анхан шатны тусламжийг үзүүлэхэд чиглэн үйл ажиллагаа явуулж байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТЦОГТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Эхний үлдэгдэл	2. Эцсийн үлдэгдэл
1	1.1 ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	368,264,638.07	409,297,541.11
31	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	3,376,008.1	134,420,496.58
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	3,376,008.1	134,420,496.58
31210	Төгрөг	3,376,008.1	134,420,496.58
31211	Төрийн сангийн харилцах	3,376,008.1	134,420,496.58
33	АВЛАГА	220,057,406.53	110,347,741.95
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	220,057,406.53	110,347,741.95
35	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	144,831,223.44	164,529,302.58
35100	Түүхий эд материал	76,676,433.43	82,017,384.45
35110	Тусгай зориулалттай материал	2,599,450	2,499,450
35130	Эм боох материал	74,076,983.43	79,517,934.45
35400	Хангамжийн материал	67,079,435.01	81,436,563.13
35410	Бичиг хэргийн материал	4,586,620	3,932,070
35420	Аж ахуйн материал	35,157,509	42,618,462
35440	Түлш, шатах тослох материал	4,865,400	6,365,000
35450	Барилгын засварын материал	122,100	90,600
35460	Хүнсний материал	11,706,468.49	18,868,193.61
35470	Бусад хангамжийн материал	10,641,337.52	9,562,237.52
35500	Биологийн хөрөнгө	1,075,355	1,075,355
2	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,753,855,330.02	1,697,808,345.84
39	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,753,855,330.02	1,697,808,345.84
39200	Биет хөрөнгө	1,718,358,871.73	1,662,528,387.59
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,536,324,771.87	1,630,441,245.87
39202	Хуримтлагдсан элэгдэл	-360,538,288.06	-395,272,474.48
39203	Авто-тээврийн хэрэгсэл	152,298,560.5	152,298,560.5
39204	Хуримтлагдсан элэгдэл	-101,682,026.13	-126,315,809.52
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	861,504,653.13	891,918,753.13
39206	Хуримтлагдсан элэгдэл	-387,580,141.53	-509,482,343.68
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	54,899,598.22	60,709,598.22
39208	Хуримтлагдсан элэгдэл	-37,718,663.41	-42,081,642.56
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,810,000	2,810,000
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,959,592.86	-2,497,499.89
39300	Биет бус хөрөнгө	35,496,458.29	35,279,958.25
39301	Програм хангамж	3,320,000	3,320,000
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,389,541.71	-1,606,041.75

Хутаг-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

39303	Бусад биет бус хөрөнгө	33,566,000	33,566,000
3	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	2,122,119,968.09	2,107,105,886.95
4	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР	42,083,000	6,186,530
41	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	42,083,000	6,186,530
41300	Өглөг	42,083,000	6,186,530
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	42,083,000	6,055,030
41360	Бусад өглөг	0.0	131,500
41361	Байгууллагад төлөх өглөг	0.0	131,500
5	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,080,036,968.09	2,100,919,356.95
51	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо	2,080,036,968.09	2,100,919,356.95
51100	Засгийн газрын оруулсан капитал	743,295,181.25	743,295,181.25
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	743,295,181.25	743,295,181.25
51200	Хуримтлагдсан үр дүн	872,510,499.21	893,392,888.07
51210	Өмнөх үеийн үр дүн	832,271,527.41	872,510,499.21
51220	Тайлант үеийн үр дүн	40,238,971.8	20,882,388.86
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	464,231,287.63	464,231,287.63
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	2,122,119,968.09	2,107,105,886.95

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,753,038,946.55	2,159,272,100.91
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	202,944,758.77	2,159,272,100.91
120	Нийтлэг татварын бус орлого	202,944,758.77	228,482,947.71
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	30,812,800	107,197,218.29
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	30,812,800	107,197,218.29
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	124,893,429.83	97,615,574
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	47,238,528.94	23,670,155.42
122	Тусламжийн орлого	0.0	1,930,789,153.2
1221	Хандив тусламж /дотоод/	0.0	1,930,789,153.2
12215	Төсөв хоорондын хандив, тусламж	0.0	1,930,789,153.2
122151	Улсын эмнэлгүүдэд ЭМДС-с олгох шилжүүлгийн орлого \ЭМДС-УТ\	0.0	1,930,789,153.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,550,094,187.78	0.0
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,550,094,187.78	0.0

Хутаг-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,550,094,187.78	0.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,705,562,987.39	2,138,389,712.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,705,562,987.39	2,138,389,712.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,705,562,987.39	2,046,994,675.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,153,256,187.08	1,455,045,953.73
210101	Үндсэн цалин	559,216,454.65	629,400,005.37
210102	Нэмэгдэл	507,656,227.91	700,585,782.24
210103	Унаа хоолны хөнгөлөлт	52,362,018.18	58,795,111.11
210104	Урамшуулал	34,021,486.34	66,265,055.01
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	137,678,900	156,569,737.63
210201	Тэтгэврийн даатгалын зардал	94,942,600	118,403,930.93
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	10,684,000	9,569,687.51
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	5,342,200	4,792,600
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	5,342,200	4,792,600
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	21,367,900	19,010,919.19
2104	Хангамж, бараа материалын зардал	51,335,951.4	51,094,456.65
210401	Бичиг хэрэг	3,351,940	3,975,400
210402	Тээвэр, шатахуун	35,180,000	24,250,400
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	443,950	1,921,340
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	11,588,550	19,768,216.65
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	771,511.4	1,179,100
2105	Нормативт зардал	171,442,025.48	164,447,169.19
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	148,925,647.48	139,254,773.31
210502	Хоол, хүнс	22,516,378	25,192,395.88
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.0	15,871,500
210604	Урсгал засвар	0.0	15,871,500
2107	Томилолт, зочны зардал	3,246,200	9,715,500
210702	Дотоод албан томилолт	3,246,200	9,715,500
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,921,319	4,213,200
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,380,000	4,097,600
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000	0.0
210803	Даатгалын үйлчилгээ	317,745	89,100
210804	Тээврийн хэрэгслийн татвар	103,940	0.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000	0.0

Хутаг-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	426,370	0.0
210807	Газрын төлбөр	116,264	0.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.0	26,500
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	185,682,404.43	190,037,158.18
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.0	3,649,600
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	185,682,404.43	186,387,558.18
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.0	91,395,036.67
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.0	91,395,036.67
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.0	29,313,036.67
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.0	62,082,000
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	47,475,959.16	20,882,388.86
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	7,236,987.36	0
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	7,236,987.36	0
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	-7,236,987.36	0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	40,238,971.8	20,882,388.86

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,395,527,700.25	2,147,696,036.07
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	30,812,800	2,147,696,036.07
120	Нийтлэг татварын бус орлого	30,812,800	107,197,218.29
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	30,812,800	107,197,218.29
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.0	3,525,280
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	30,812,800	103,671,938.29
122	Тусламжийн орлого	0.0	2,040,498,817.78
1221	Хандив тусламж /дотоод/	0.0	2,040,498,817.78
12215	Төсөв хоорондын хандив, тусламж	0.0	2,040,498,817.78
122151	Улсын эмнэлгүүдэд ЭМДС-с олгох шилжүүлгийн орлого \ЭМДС-УТ\	0.0	2,040,498,817.78
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,364,714,900.25	0.0
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,364,714,900.25	0.0

Хутаг-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,364,714,900.25	0.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,463,480,358.78	1,998,896,547.59
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,463,480,358.78	1,998,896,547.59
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,463,480,358.78	1,907,501,510.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,153,256,187.08	1,455,045,953.73
210101	Үндсэн цалин	559,216,454.65	629,400,005.37
210102	Нэмэгдэл	507,656,227.91	700,585,782.24
210103	Унаа хоолны хөнгөлөлт	52,362,018.18	58,795,111.11
210104	Урамшуулал	34,021,486.34	66,265,055.01
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	137,678,900	156,569,737.63
210201	Тэтгэврийн даатгалын зардал	94,942,600	118,403,930.93
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	10,684,000	9,569,687.51
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	5,342,200	4,792,600
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	5,342,200	4,792,600
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	21,367,900	19,010,919.19
2104	Хангамж, бараа материалын зардал	37,667,330	43,229,120
210401	Бичиг хэрэг	3,769,440	3,110,850
210402	Тээвэр, шатахуун	19,000,000	25,750,000
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,296,740	2,121,340
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,841,600	4,915,200
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,759,550	7,331,730
2105	Нормативт зардал	108,228,412.7	199,129,249.56
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	80,644,291.7	156,934,267.56
210502	Хоол, хүнс	24,583,121	37,134,982
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,001,000	5,060,000
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,501,400	34,162,650
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.0	14,970,000
210604	Урсгал засвар	16,501,400	19,192,650
2107	Томилолт, зочны зардал	3,246,200	9,715,500
210702	Дотоод албан томилолт	3,246,200	9,715,500
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,890,529	4,516,700
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,380,000	4,097,600
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000	0
210803	Даатгалын үйлчилгээ	317,745	89,100
210804	Тээврийн хэрэгслийн татвар	103,940	0.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000	0.0

Хутаг-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	395,580	0.0
210807	Газрын төлбөр	116,264	0.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.0	330,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,011,400	5,132,600
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,011,400	5,132,600
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.0	91,395,036.67
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.0	91,395,036.67
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.0	29,313,036.67
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.0	62,082,000
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-67,952,658.53	148,799,488.48
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	42,328,000	17,755,000
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	42,328,000	17,755,000
2200	Дотоод эх үүсвэрээр	42,328,000	17,755,000
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	42,328,000	17,755,000
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-42,328,000	-17,755,000
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-110,280,658.53	131,044,488.48
101	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	113,656,666.63	3,376,008.1
20	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,376,008.1	134,420,496.58

Хутаг-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Устгалын өмнөх			
		1.1 Засгийн газрын оруулсан капитал	1.2 Дахин үнэлгээний нөөц	1.3 Хуримтлагдсан үр дүн	1.4 Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	743,295,181.25	464,231,287.63	832,271,527.41	2,039,797,996.29
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	743,295,181.25	464,231,287.63	832,271,527.41	2,039,797,996.29
9	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	40,238,971.8	40,238,971.8
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	743,295,181.25	464,231,287.63	872,510,499.21	2,080,036,968.09
11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	743,295,181.25	464,231,287.63	872,510,499.21	2,080,036,968.09
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	743,295,181.25	464,231,287.63	872,510,499.21	2,080,036,968.09
19	1.7 Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	20,882,388.86	20,882,388.86
20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	743,295,181.25	464,231,287.63	893,392,888.07	2,100,919,356.95

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Төлөвлөгөө	2. Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	2,195,631,100	2,147,696,036.07
12	Татварын бус орлого	2,195,631,100	2,147,696,036.07
120	Нийтлэг татварын бус орлого	134,420,100	107,197,218.29
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	0.0	3,525,280
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	134,420,100	103,671,938.29
122	Тусламжийн орлого	2,061,211,000	2,040,498,817.78
122001	Хандив тусламж /дотоод/	2,061,211,000	2,040,498,817.78
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,199,819,900	2,016,651,547.59
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,199,819,900	2,016,651,547.59
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,071,319,800	1,925,256,510.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,526,169,600	1,455,045,953.73
210101	Үндсэн цалин	678,677,700	629,400,005.37
210102	Нэмэгдэл	741,993,400	700,585,782.24
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,298,500	58,795,111.11
210104	Урамшуулал	90,200,000	66,265,055.01
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	190,186,700	156,569,737.63
210201	Тэтгэврийн даатгал	130,711,000	118,403,930.93
210202	Тэтгэмжийн даатгал	14,869,000	9,569,687.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,434,400	4,792,600
210204	Ажилгүйдлийн даатгал	7,434,400	4,792,600
210205	Эрүүл мэндийн даатгал	29,737,900	19,010,919.19
2104	Хангамж, бараа материалын зардал	57,074,700	43,229,120
210401	Бичиг хэрэг	4,227,300	3,110,850
210402	Тээвэр, шатахуун	34,867,000	25,750,000
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,268,200	2,121,340
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,712,200	4,915,200
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,000,000	7,331,730
2105	Нормативт зардал	208,377,000	199,129,249.56
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	167,319,200	156,934,267.56
210502	Хоол, хүнс	35,997,800	37,134,982
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,060,000	5,060,000
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	60,486,500	51,917,650
210601	Багаж, техник, хэрэгсэл	32,725,000	32,725,000
210604	Урсгал засвар	27,761,500	19,192,650
2107	Томилолт, зочны зардал	13,576,700	9,715,500

Хутаг-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

210702	Дотоод албан томилолт	13,576,700	9,715,500
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,046,700	4,516,700
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,833,100	4,097,600
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000	0
210803	Даатгалын үйлчилгээ	318,000	89,100
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200,000	0.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	150,000	0.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	475,600	0.0
210807	Газрын төлбөр	120,000	0.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	450,000	330,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,401,900	5,132,600
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,401,900	5,132,600
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	128,500,100	91,395,036.67
2132	Бусад урсгал шилжүүлэг	128,500,100	91,395,036.67
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	66,418,100	29,313,036.67
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	62,082,000	62,082,000
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-4,188,800	131,044,488.48
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,188,800	-131,044,488.48
7	3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	4,188,800	-131,044,488.48
4	4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	3,376,008.1
5	5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	134,420,496.58
650009	6.5.09 Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	9	9

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хутаг-Өндөр сумын Эрүүл мэндийн төв нь харьяа нутаг дэвсгэрийн хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэх эрүүл мэндийн төрийн үйлчилгээний байгууллага юм.

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Хутаг-Өндөр сумын ЭМТөв нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд үйлчлүүлэгчийн биеийн байдалд үнэлгээ өгөх, хянах, эрүүл мэндийг дэмжих, аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэхэд орчин үеийн болон уламжлалт анагаах ухаанд тулгуурлан эмнэлгийн анхан шатны тусламжийг үзүүлэхэд чиглэн ажиллаж байна.

Хутаг-Өндөр Эрүүл мэндийнх төв нь анхан шатны тусламж үйлчилгээ ба дараах чиг үүргүүдийн дагуу 6 зорилтын хүрээнд 48 ажил төлөвлөж, сумын Засаг Даргын 2025-2028

оны үйл ажилгааны “Хутаг-Өндөрийн сэргэлт” хөтөлбөрийн хүрээнд 1 зорилт 10 ажил төлөвлөж нийтдээ 7 зорилт 58 ажлыг 90%-тай авч хэрэгжүүлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Хутаг-Өндөр сумын Эрүүл мэндийн төв нь үйл ажиллагаандаа Эрүүл мэндийн тухай хууль, ЭМДҮЗ-өөс гаргасан тогтоолууд, НЭМ-ийн тухай хууль, эм эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, төсвийн тухай хууль, төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, хөдөлмөрийн тухай хууль, НББ-ийн тухай хууль, тааварын тухай хууль, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, нийгмийн даатгалын тухай хууль, шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол, Засгийн газрын 2019 оны 5, 6, 7 дугаар тогтоол, Засгийн газрын 2024 оны 39 дугаар тогтоол, Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоол, Сангийн сайдын 2024 оны А/50 дугаар тушаал болон эрүүл мэндийн салбарт мөрдөгдөж буй хууль эрх зүйн акт, тогтоол, шийдвэр тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад дүрэм, журам стандартыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Төсвийн шууд захирагч батлагдсан төсөвт үндэслэн зарлагын гүйлгээг цахимаар хянаж баталгаажуулснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол сумын төрийн сан холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичиг, зарлагын гүйлгээг хянан баталгаажуулан ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, НББ-д мөрддөг хууль тогтоомжид орсон өөрчлөлт Засгийн газрын 238 тогтоолоор “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээ”-г шинэчлэн тогтоож 2025 оны 01 сарын 1-ний өдрөөс мөрдлөг болгосон, Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам” батлах тухай А/03 дугаар тушаалууд болно.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Дотоод хяналтын баг нь 3 хүний бүтэц бүрэлдэхүүнтэй байгуулагдсан. Байгууллагын Дотоод хяналтын багийн ажиллах журмыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 6.4 заасны дагуу МУЗГ-ын 2011 оны 11 сарын 09 өдрийн 311 тогтоолыг үндэслэн боловсруулан, батлан, мөрдөн ажиллахаас гадна байгууллагын үйл ажиллагаанд “Дотоод хяналт, шалгалт зохион байгуулах журам”-ыг боловсруулан ажиллаж байна. 2025 онд дотоод хяналтын баг нь нийгмийн даатгалын байгуулагаас анхан шатны баримт материал, цахим хөтлөлт дутуу шалтгаанаар эмнэлгийн тусламж үйлчилгээний санхүүжилтийн орлого тасалдаж байгаа тул төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж цахим бүртгэл, тусламж үйлчилгээний санхүүжилтийг нэмэгдүүлэх талаар заавар зөвлөгөө өгөн, үйлчилгээ үзүүлсэн цахим бүртгэлийг ажлын үр дүнтэй уялдуулан ажиллах талаарх мэдээллийг өгч илтгэх хуудсыг бичин байгууллагын удирдлагад танилцуулан ажилласан.

Дотоод хяналтын баг нь 2025 онд хийх ажлын график төлөвлөгөө, цаашид хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, сургалтын төлөвлөгөөг оны эхэнд гаргаж батлуулсан ба хяналт шалгалт хийсэн ажлын дүгнэлт, илтгэх хуудсыг бичин баримтжуулан ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үеийн шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагаа нь аудитын үйл ажиллагаанд үр нөлөөгүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хутаг-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Хутаг-Өндөр сумын Эрүүл мэндийн төв нь Булган аймгийн Засаг даргын 2020 оны 09 дүгээр сарын 29-ны өдрийн А/424 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох

бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ыг мөрдөж ажиллаж байна. Энэ нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч Эрүүл мэндийн тухай хууль, шинэчлэгдсэн журам, гүйцэтгэл, үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлт, санхүүжилтийн бүртгэлийн талаар тусгагдаагүй учраас тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан шинэчлэх шаардлага үүсэж байна.

Нягтлан бодох бүртгэлийн хөтлөлтийг "FISCUS онлайн" санхүүгийн тооцоолох программыг ашиглаж байна. Санхүүгийн программ нь Сангийн яаманд хүлээн зөвшөөрөгдсөн, төсвийн байгууллагын онцлогт тохирсон данс, бүртгэлийн системтэй бөгөөд УСНББОУС, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд нийцсэн иж бүрэн санхүүгийн тайланг бэлтгэхэд ашиглаж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хутаг-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 15,014.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/				
№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
1	Б	1	2	3=2-1
2	Мөнгөн хөрөнгө	3,376.0	134,420.4	131,044.4
3	Авлага	220,057.4	110,347.7	-109,709.7
4	Бараа материал	144,831.2	164,529.3	19,698.1
5	Үндсэн хөрөнгө	1,753,855.3	1,697,808.3	-56,047.0
Нийт хөрөнгө		2,122,119.9	2,107,105.8	-15,014.1
7	Богино хугацаат өр төлбөр	42,083.0	6,186.5	-35,896.5
8	Засгийн газрын хувь оролцоо /эздийн өмч/	2,080,036.9	2,100,919.3	20,882.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө, өмчийн дүн		2,122,119.9	2,107,105.8	-15,014.1

Дээрх хүснэгтээс харахад нийт хөрөнгө өмнөх оноос 15,014.1 мянган төгрөгөөр буурсан харагдаж байгаа боловч мөнгөн хөрөнгө, тусламж үйлчилгээний орлого буурсан үзүүлэлттэй байна.

Тайлант онд нийт 2,288,080.3 мянган төгрөгийн санхүүжилтийг авч 2,157,037.8 мянган төгрөгийн зарцуулалт хийгдэж 134,420.4 мянган төгрөгийн дансны үлдэгдэлтэй гарсан байна.

Авлага урд оныхоос 109,709.7 мянган төгрөгөөр буурсан нь Эрүүл мэндийн даатгалын сангаас авах тусламж үйлчилгээний орлогын урьд оны авлага бүрэн барагдсантай холбоотой.

Бараа материалын дансны үлдэгдэл 164,529.3 мянган төгрөг болж 2024 оноос 19,698.1 мянган төгрөгөөр өссөн ба төсвийн хөрөнгөөр 255,580.4 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг хийж, ХӨСҮТ болон Булган аймгийн ЭМГ-аас 23,670.1 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлэн орлогод авсан байна. Тайлангийн хугацаанд 259,552.5 мянган төгрөгийн материалыг зарцуулсан.

Өглөгийн дансанд эмийн өглөг 19,423.9 мянган төгрөг, бусад өглөг 2,350.6 мянган төгрөг нийт 21,774.5 мянган төгрөгийн өглөгтэй гарсан нь тусламж үйлчилгээний орлого цахим бүртгэл дутуу шалтгаанаар хасагдсанаас үүссэн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,697,808.3 мянган төгрөг болж өмнөх оныхоос 56,047.0 мянган төгрөгөөр буурсанд тайлангийн хугацааны тооцоолсон 186,387.5 мянган төгрөгийн элэгдлийн зардал нөлөөлсөн байна. Эрүүл мэндийн газраас 3,499 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, Булган аймгаас 94,116.4 мянган төгрөгийн эмнэлгийн барилгад хийгдсэн их засварыг хийж капиталжуулан үндсэн хөрөнгийн дансанд үнэ төлбөргүй авч санхүүгийн тайланд тусгасан. Тайлангийн хугацаанд 26,915.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 5,810.0 мянган төгрөгийн тавьлга эд хогшлийг худалдан авсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Хутаг-Өндөр сумын Эрүүл мэндийн төв нь байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг ЭМДСангаас 2,061,211 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн ба байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 99,618.10 мянган төгрөгөөр төлөвлөн орон нутгийн төрийн санд хүргүүлсэн байна. Орон нутгийн төсвөөс 99,618.1 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, 30,000.0 мянган төгрөг урд оны санхүүжилтээр авч, 140,384.3 мянган төгрөг санхүүжилтээр авч нэг удаагийн төсвийн тодотголоор 29,997.9 мянган төгрөг хасуулж нийт 110,386.4 мянган төгрөгийг санхүүжилт авч ажилсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Хутаг-Өндөр сумын Эрүүл мэндийн төв нь гүйцэтгэлийн санхүүжилтээр санхүүжиж үндсэн 4 тусламж үйлчилгээ буюу гүйцэтгэлээр 535,041.4 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 585,452.8 мянган төгрөгийн санхүүжилтийг ЭМДСангаас авч, нэг иргэний санхүүжилтээр 1,526,169.6 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 1,455,045.9 мянган төгрөгийн санхүүжилтийг ЭМДСангаас авч үлдэгдэл 134,420.4 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
71602-Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ					
1.1	80302-Нэг иргэн	1,526,169.6	1,455,045.9	71,123.7	95.3
1.2	81603- Үндсэн тусламж	535,041.4	585,452.8	-50,411.4	109.4
1.3	83603-Дээд шатнаас хуваарилсан				
ОРОН НУТАГ УРСГАЛ САНХҮҮЖИЛТ					
71602- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ					
1.1	80111-Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	99,618.1	110,386.4	10,768.3	110.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд салбарын хэмжээнд нэмэлт санхүүжилтийн дансыг хаасан бөгөөд нэмэлт санхүүжилтийн дансаар ажил гүйлгээ хийгдээгүй, аваагүй болно.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд төсөл, хөтөлбөр хэрэгжээгүй болно.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд зааснаар гэрээ шууд байгуулах тухай зарлалыг бараа, ажил, үйлчилгээний ерөнхий мэдээллийн хамт цахим системд нийтэлж, энэ хуулийн 54.8-д зааснаар аж ахуй эрхлэгчид хэлэлцээ хийх урилга хүргүүлээгүй байна. Засгийн газрын 2024 оны 1 сарын 3-ны 02 дугаар тогтоолоор баталсан босго үнийг баримталсан.

Хутаг-Өндөр сумын Эрүүл мэндийн төв нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 255,580.4 мянган төгрөгийн бараа материал, 32,725.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр, төрөл	Төрөл	Төсөвт өртөг (мян.төг)	Гэрээ байгуулсан дүн	Гэрээ байгуулсан этгээдийн нэр
Бичиг хэргийн зардал	Бараа	3,215.8	3,215.8	Монгол шуудан ХХК, Дугаржав Тоймаа
Тээвэр шатахууны зардал	Бараа	25,750.0	25,750.0	Петровис ХХК
Шуудан холбооны зардал	Үйлчилгээ	2,121.3	2,121.3	МЦХолбоо ХХК, БЧАТГ ХХК
Урсгал засвар	Бараа	19,192.6	19,192.6	О.Мөнхбаяр, Шууз ХХК, Цахирын Буянт ХХК, Хүрээ Хутаг ХХК, Х.Ганчимэг
Эм эмнэлгийн ороох боох зардал	Бараа	119,422.5	100,650.0	Булган монос фарм ХХК, Булган эм импекс ХХК, Монбио фарм ХХК, Пролианс ХХК, Медклинин ХХК, Энто ХХК, Булган НЭмнэлэг,
Хоол	Бараа	32,354.1	28,800.0	БЧАТГ ХХК, Отгонпүрэв, Их Хаадын Хүнс ХХК, Ямранз
Дүн		202,056.3	179,729.7	

Тайлант онд эмийн зардалд батлагдсан төсвөөс 100,650.0 мянган төгрөгийн эм эмнэлгийн хэрэгсэл, ороох боох материалыг худалдан авсан ба худалдан авалтыг шууд гэрээгээр хийсэн байна. Цахим худалдан авалтыг хийгээгүй шалтгаан нь цахим худалдан авалт хийх нөхцөл нь бүрдээгүй, худалдан авах ажиллагааны чиглэлээр сургалтанд хамрагдсан алба хаагч байгаагүй зэргээс шалтгаалан нэвтэрч чадаагүй байна.

3.6 Үндэсний аудитын газраас ирүүлсэн ерөнхий чиглэлийн хүрээнд авсан судалгааны үр дүнгийн талаар:

- Гадаад томилолт тухайн байгууллагад байхгүй.
- Төрд учирсан хохирлыг ббарагдуулахтай холбоотой гарсан зардал тайлант онд үүсээгүй.
- Тус газар нь тайлант онд бараа ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулсан.
- Санхүүгийн тооцоолох группын Fiscus программыг 2024 оноос ашигласан.
- 2025 онд орон тооны цомхотгол хийгдээгүй болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хутаг-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах Төсвийг зохистой удирдаж, зориулалтын дагуу зарцуулах, эд хариуцагчтай хөдөлмөрийн гэрээ байгуулах талаар болон Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Бэйкер тилли Далайван аудит” ХХК-ийн Орхон аймаг дахь салбарын аудитор Б.Пүрэвсүрэн гүйцэтгэж анхан шатны чанарын хяналтыг салбарын захирал, аудитор Д.Мягмарсүрэн, хоёр дахь шатны чанарын хяналтыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Ж.Энхцоодол, газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Батцогт нар хэрэгжүүлэв.

Хутаг-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн 1,786,744.2 мянган төгрөгийн нийт зардлаас 2 хувиар тогтоож сонгосон суурь үзүүлэлтээс тооцож 35,734.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 25,014.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2- 15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

Мөн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох, нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх, хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох зэрэгтэй холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хутаг-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны шилэн дансны нэгдсэн цахим хуудасны мэдээллээс дараах мэдээллийг түүвэрлэн шалгахад шалгалаа. Санхүүгийн тайлангийн аудит хийхэд баримтлах ерөнхий бодлого, чиглэлийн дагуу Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, үндсэн хөрөнгө, бараа материалын биет тооллого, төсвийн орлого, зардлын зарцуулалттай холбоотой асуудлуудыг хянахаар тусгайлан авч үзсэн зөрчил илрээгүй боловч хугацаа хоцроон мэдээлсэн зарчил харагдаж байх тул дараагийн аудитаар шалгахад дурдсан болно.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцлийн асуудлыг үнэлэх асуудал үүсээгүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Хутаг-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн болно.

Санхүүгийн тайлангийн аудит хийхэд баримтлах ерөнхий бодлого, чиглэлийн дагуу Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, үндсэн хөрөнгө, бараа материалын биет тооллого, төсвийн орлого, зардлын зарцуулалттай холбоотой асуудлыг хянахаар тусгайлан авч үзсэн.

4.5.1 Завсрын аудитын талаар

Хутаг-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн болно. Завсрын аудитаар санхүүгийн тайлагнал, бараа материалын данс, үндсэн хөрөнгийн данс, цалингийн дансанд нийт 507,829.2 мянган төгрөгийн 16 зөрчил илэрүүлэн залруулах буюу шийдвэрлэхийг зөвлөсөн боловч арга хэмжээ аваагүй болно..

Завсрын аудитаар 5-н зөвлөмжийг өгсөн бөгөөд биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянан үзэхэд биелэлт хангасан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар нийт 61,591.9 мянган төгрөгийн зөрчил 1 илэрснээс 86.1 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 1 зөвлөмж, 61,505.8 мянган төгрөгийн 2 албан шаардлага өгсөн.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	86.1	2	86.1	100%
Албан шаардлага	2	61,505.8	2	61,505.8	100%
Зөвлөмж	1		2		100%
Нийт дүн	5	61,591.9	5	61,591.9	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар илэрсэн зөвлөмж болон хүргүүлсэн асуудлуудын хэрэгжилт, худалдан авах ажиллагааны гэрээ, тендэр шалгаруулалт, мөн шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт зэргийг анхаарч ажиллах хэрэгтэй гэж үзэж байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 469,227,517.8 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 3,351.9 мянган төгрөгийн 4 төлбөрийн акт, 151,570.5 мянган төгрөгийн 6 албан шаардлага, 314,205.1 мянган төгрөгийн 14 зөвлөмж өгсөн.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн материаллаг 122,335.9 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс давсан нь санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй учир “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн болно.

5.1 Төлбөрийн акт

- **Илрүүлэлт:** Албан хаагчдийн хоолны нэмэгдлийг албан томилолтоор ажилласан хугацаанд давхардуулан 530.0 мянган төгрөг илүү тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам"-ын 2.2. Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараахь зардлаас бүрдэнэ: 2.2.1. "унааны зардал"; 2.2.2. "байрны зардал" 2.2.3. "хоолны зардал" гэж олгодог мөнгийг давхардуулан олгосон зөрчил байна.
- **Илрүүлэлт:** Булган аймгийн эрүүл мэндийн газрын даргын 2025 оны 09 сарын 19-ний өдрийн А/70 тоот эрх зүйн үндэслэлгүй тушаалыг үндэслэн байгууллагын даргын Б/24 тоот тушаалаар статистикч эмчид 585.8 мянган төгрөгийн урамшууллыг улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 3.2. "Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг үндэслэн үндсэн цалингийн 10-20 хувиар сар бүр тооцож, улирал тутам олгоно", Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах" 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дүгээр зүйлийн 15.1.3. "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэсэн заалт зөрчигдөж байна.
- **Илрүүлэлт:** Шатахууны тооцооллыг шалгахад шатахууны хөнгөлөлт, урамшууллын 772.5 мянган төгрөгийн шатахууныг үнэ төлбөргүй орлогоор бүртгэлд тусгаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14 дүгээр зүйлийн 14.4.5 "бүх орлого", Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын заалтууд зөрчигдөж байна.
- **Илрүүлэлт:** Аймгийн эрүүл мэндийн даргын тушаалаар Б.Туяацэцэгийг, байгууллагын даргын 2025 оны 12 сарын 25-ний өдрийн Б/26 тоот тушаалаар В.Байгалмааг тус бүр үндсэн цалингийн 50 хувиар нийт 1,463.6 мянган төгрөгийн урамшууллыг улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэж заасныг зөрчсөн байна

5.2 Албан шаардлага

- **Илрүүлэлт:** Амбулаторын барилгын ажилд хийгдсэн 94,116.4 мянган төгрөгийн, төрөхийн өмнөх барилгын 2,500.0 мянган төгрөгийн засварын

ажлыг уг барилгад капиталжуулаагүй, үндсэн хөрөнгийн дансанд нийт 96,616.4 мянган төгрөгийг засварын ажил гэж бүртгэсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 5 дүгээр зүйлийн 5.1.2."төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" УСНББОУС 17-н 24.25 параграф "Барилгын дотор ханыг солих гэх мэт цөөн давтагдах эсвэл дахин үл давтагдах орлуулалт хийх тийм үндсэн хөрөнгийн зүйлсийг мөн олж бэлтгэж болох юм". 14-р параграфт заасан хүлээн зөвшөөрөлтийн зарчмын дагуу," байгууллага нь ийм зүйлсийн орлуулан нэмэгдэж буй хэсгийг хэрэв хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангаж байвал тухайн өртөг зардал гарсан үед үндсэн хөрөнгийн дансны үнэд оруулан хүлээн зөвшөөрнө" гэсэн заалт хэрэгжээгүй байна.

- Илрүүлэлт: Санхүүгийн тайланд Уньт багийн эмнэлгийн барилга бүртгэлгүй байтал Уньт багийн эмнэлгийн барилгад "Уньт эмнэлэг худаг" 9,500.0 мянган төгрөг, "Уньт баг цэвэр бохир ус" 3,500.0 мянган төгрөгийн засварын ажлууд хийгдэж мөн Хонгор багт эмнэлгийн барилга биетээр байхгүй гэх боловч 2,679.6 мянган төгрөгийг "Хонгор эмнэлэг засвар" гэж нийт 15,679.6 мянган төгрөгийг барилга байгууламжийн дансанд хий засварууд бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4.үнэн зөв байх; Төрийн болон орон нутгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2.Төрийн байгууллага, албан газар төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг нь өөрт олгогдсон эд хөрөнгийн талаар дараахь эрх, үүрэгтэй: 1/ "өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах" 2/ "улсын төсвөөс олгосон хөрөнгийг Төсвийн тухай хуульд заасны дагуу зарцуулж, тайлагнах" гэж заасны дагуу хөрөнгөнд хяналт тавьж ажилладаггүй байна.
- Илрүүлэлт: Тус эмнэлгийн хашаанд орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2020 онд Моргийн байшин баригдсан ч бүртгэлд тусгагдаагүй, харин акталсан Сүрлэн барилгыг бүртгэлээс хасаагүй тэг үлдэгдэлтэй, эмийн санд түрээслүүлэн ашиглаж байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх" 5.1.5-д "хэмжигдэхүйц байх", 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалын "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 1 хавсралт 10.26."Хөрөнгийн үлдэх өртөг, ашиглахаар тооцсон үлдсэн хугацаа, элэгдлийн аргыг санхүүгийн жил бүрийн эцэст хянаж, тооцооллын өөрчлөлтийг гүйцээх горимоор бүртгэнэ" Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2-т "Төрийн байгууллага, албан газар төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг нь өөрт олгогдсон эд хөрөнгийн талаар дараах эрх, үүрэгтэй,1/ "өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах" заалтууд зөрчигдөж байна.
- Илрүүлэлт: Тээврийн хэрэгслийн дансанд бүртгэлтэй 29,736.4 мянган төгрөгийн анхны өртөгтэй элэгдлээрээ өртгөө нөхсөн Пургон маркийн авто машиныг Цагдаагийн байгууллагад шилжүүлсэн, эмнэлэгт ашиглагддаггүй биетээр байхгүй ч санхүүгийн тайланд бүртгэлтэй хэвээр байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4."үнэн зөв байх"; 5 дугаар зүйлийн 5.1.5."хэмжигдэхүйц байх", ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоол 2.3. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага хооронд хөдлөх үндсэн хөрөнгө шилжүүлэх хүсэлтийг судлан үзэж тухай бүр нь зөвшөөрөл олгож байх" 5.6. Элэгдэл, хорогдлын шимтгэлээр өртгөө нөхсөн хөрөнгийг шилжүүлэх асуудлыг шийдвэрлүүлэхдээ энэ журмын 7.1-д заасны дагуу "тухайн хөрөнгийн

ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналын хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ". гэсэн заалтууд зөрчигдсөн байна.

- **Илрүүлэлт:** Тээврийн хэрэгслийн дансанд бүртгэлтэй 6.688.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй элэгдлээрээ өртгөө нөхсөн 4 ширхэг мотоциклийг актлуулах шийдвэр гаргуулаагүй, данснаас хасаагүй боловч биетээр байхгүй, хөрөнгийг ашиглагдахгүй болонгуут заавар журмын дагуу актлуулж данснаас хасахгүй устгаж үгүй болгодог зөрчил харагдаж байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4.үнэн зөв байх; 5 дугаар зүйлийн 5.1.5.хэмжигдэхүйц байх, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 1/ өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах, 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлийн 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ".2.3. "Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага хооронд хөдлөх үндсэн хөрөнгө шилжүүлэх хүсэлтийг судлан үзэж тухай бүр нь зөвшөөрөл олгож байх"; гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй.
- **Илрүүлэлт:** Үндсэн хөрөнгө, бараа материалын дансанд тооллого чанартай хийгддэггүй, тооцоо бодож эд хариуцагч нэг бүрээр бүртгэлжүүлээгүй, ашигладаггүй болон үлдэгдэлгүй хөрөнгө, бараа материал бүртгэлтэй байх ба тавилга эд хогшлийн дансны үлдэгдэлд биетээр байхгүй 2.970.0 мянган төгрөгийг зөрүү гэж бүртгэсэн нь ямар хөрөнгө болох нь тодорхойгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4."үнэн зөв байх"; 5 дугаар зүйлийн 5.1.5."хэмжигдэхүйц байх" Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2.төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, Нягтлан бодох бүртгэлийн 20 дугаар зүйлийн 20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтууд зөрчигдөж байна.

5.3 Зөвлөмж

1. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд 3 албан хаагчид 1,180.7 мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмж урамшууллыг олгохдоо цалингийн зардлаас тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 22 дугаар зүйлийн 22.6.3-д "Төсвийн төлөвлөлт, бүртгэл, тайлагналыг төсвийн ангилалын төрөл тус бүрээр, тэдгээрийн дэлгэрэнгүй ангилалын дагуу бэлтгэх", Сангийн сайдын 2023 оны 211 дугаар тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ын Урамшуулалд хамаарахгүй згйлс нь НДШ төлөхгүй нэг удаагийн шинжтэй шагнал, тэтгэмж урамшаалал"гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тоног төхөөрөмжийн дансанд 64 нэр төрлийн 410 ш 20 071.8 мянган төгрөгийн БМ, тавилга эд хогшлийн дансанд 19 нэр төрлийн 45ш 1,483.6 мянган төгрөгийн БМ-ыг буруу ангилан бүртгэсэн нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн өртгийг зөвхөн дараах тохиолдолд хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө: (а) Тухайн хөрөнгөтэй холбоотой ирээдүйн

эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи нь тухайн байгууллагад орох нилээд их магадлалтай байх; ба (б) Тухайн хөрөнгийн өртөг буюу үйлчилгээний чадавхийг найдвартай хэмжиж чадах, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалын "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 1 хавсралтын 10.8."Сэлбэг, нөөцөд байгаа тоног төхөөрөмж, засвар үйлчилгээ хийгдэж буй тоног төхөөрөмж гэх мэт үйл ажиллагаанд ашиглагдахгүй байгаа зүйлс нь үндсэн хөрөнгийн тодорхойлолтыг хангасан тохиолдолд үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрнө". "Харин тодорхойлолтыг хангаагүй тохиолдолд эдгээр зүйлсийг бараа материал гэж ангилна".гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

3. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Бусад үндсэн хөрөнгийн дансанд 1,665.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, тоног төхөөрөмжийн дансанд 3,700.0 мянган төгрөгийн тавилга эд хогшлийг тус бүр ангилал буруу бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4."үнэн зөв байх" УСНББОУС 17: 52 парагаф Үндсэн хөрөнгийн анги гэдэг нь байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах байдлын хувьд ижил төсөөтэй шинж төрөл ба хэрэглээ бүхий хөрөнгүүдийн бүлэг юм, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалын "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

4. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн тэг үлдэгдэлтэй 286,103.7 мянган төгрөгийн анхны өртөгтэй 103 нэр төрлийн 187 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3."холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", ТӨБЗГын 2019 оны 271 тогтоол 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ." гэсэн заалт зөрчигдөж байна..

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.Шалгадагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 6 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шатахууны хөнгөлөлтийн орлого бүртгэлд тусгаагүй	1	772.5	1	772.5								
Томилолтоор ажилласан ажилтанд хоолны мөнгө давхардуулан олгосон	1	530.0	1	530.0								
Үр дүнгийн урамшуулал давхардуулан олгосон.	1	585.8	1	585.8								
Үр дүнгийн урамшуулал давхардуулан олгосон.		1,463.6	1	1,463.6								
Их засварын ажлыг барилгад капиталжуулж бүртгээгүй.	1	96,616.4			1	96,616.4						
Санхүүгийн тайланд бүртгэлгүй барилгад засвар хийгдэж үндсэн хөрөнгийн дансанд засварын ажил гэж бүртгэсэн	1	15,679.6			1	15,679.6						
Бүртгэлгүй барилга эзэмшиж байх ба актлах хөрөнгийг түрээслүүлсэн	1				1							
Санхүүгийн бүртгэлд тусгагдсан боловч гэрээ хэлцэлгүй бусад төсвийн байгууллага ашиглагддаг	1	29,736.4			1	29,736.4						
Биетээр байхгүй хөрөнгө/ мотоцикл/ үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй байна.	1	6,688.0			1	6,688.0						
Үндсэн хөрөнгийн дансанд хий бүртгэл хөтөлсөн.	1	2,970.0			1	2,970.0						
Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн тэг үлдэгдэлтэй хөрөнгө бүртгэлтэй байна.	1	274 437.6					1	274 437.6				
Зардал гүйлгэн зарцуулсан	1	1,180.7					1	1,180.7				
Хөрөнгийн ангилал буруу бүртгэсэн.	1	21,555.5					1	21,555.5				
Үндсэн хөрөнгийн дансны ангилал буруу	1	5,365.0					1	5,365.0				
Дүн	14	469,227.5	3	3,351.9	1	151,570.5	1	314,205.1				